

Шvvхийн мониторингийн зөвлөлийн 2-р сарын хуралдаан болов.

Бичсэн Administrator

2013 оны 3-р сарын 04, Даваа гариг, 09:10 - Сvvлд шинэчлэгдсэн 2013 оны 3-р сарын 04, Даваа гариг, 09:13

Шvvхийн мониторингийн зөвлөлийн 2-р сарын хуралдаан болов.

Шvvхийн Мониторингийг хэрэгжvvлэх зовлолийн ажлын хэсгийн ээлжит хуралдаан 2013 оны 02 дугаар сарын 25-нд болов.

Хуралдаанд зовлолийн ахлагч Улсын Дээд шvvхийн Иргэний хэргийн танхимын тэргvvн Б.Ундрах, ШЕЗ-ийн Гvйцэтгэх нарийн бичгийн дарга Н.Дагва, гишvvн Судалгааны товийн захирал Ч.Нямсvрэн, Захиргааны хэргийн давж заалдах шатны шvvхийн Еронхий шvvгч Ц.Цогт, Нийслэлийн шvvхийн Еронхий шvvгч Б.Сарантуяа, Нийслэлийн шvvхийн Эрvvгийн хэргийн танхимын тэргvvн Б.Батцэрэн, Шvvхийн Еронхий Зовлолийн хэлтсийн дарга С.Энхбаяр, С.Жанхор, Мэдээлэл технологийн тасгийн дарга Д.Монхзориг, Шvvхийн Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зvйн орчныг баталгаажуулах” тослийн ажилтан Б.Жавхлан, Эвлэрvvлэн зуучлах тогтолцоог сайжруулах тослийн зохицуулагч Ока Хидео, ажилтан Оюу, ШЕЗ-ийн Ажлын албаны референт Б.Энхболд нар оролцов.

Хурлаар иргэн, эрvv, захиргааны хэргийн мониторингийн ажлын хэсгийн болон эвлэрvvлэн зуучлах тогтолцоог сайжруулах тослийн 2013 оны 2 дугаар сард хийсэн ажил бусад мэдээ, мэдээллийг сонсож ярилцлаа.

Захиргааны хэргийн мониторингийн ажлын хэсгийн тендер шалгаруулах ажиллагаа дуусч, захиргааны хэргийн мониторингийн программыг “Интерактив” ХХК гvйцэтгэхээр тендерийн дvн гарсан байна. Мониторингийн ажлын хэсэг болон “Интерактив” ХХК уулзалт хийж ажлын толовлогоо гаргаснаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны программыг энэ оны 6 сарын 13-ны одор гэхэд гvйцэтгэж дуусах, шvvхийн зvгээс программыг боловсруулахад Нийслэлийн захиргааны шvvхийн шvvгч С.Монхжаргал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шvvхийн шvvгч П.Соёл-Эрдэнэ нар оролцохоор тохирчээ.

Иргэний хэргийн мониторингийн ажлын хэсэг онгорсон сард хийсэн ажлын талаар

Шvvхийн мониторингийн зөвлөлийн 2-р сарын хуралдаан болов.

Бичсэн Administrator

2013 оны 3-р сарын 04, Даваа гариг, 09:10 - Сvvлд шинэчлэгдсэн 2013 оны 3-р сарын 04, Даваа гариг, 09:13

танилцуулав. Он гарсаар ажлын хэсгээс “Иргэн-2” системийн судалгааны ажлыг дуусгаж, техникийн даалгавруудыг гvйцэтгэж 2-р шатны тендер шалгаруулах ажлын бэлтгэл хангагдсан байна. Мон мэдээллийн технологийн мэргэжилтнvvдийн сургалтыг зохион байгуулж, Иргэн-1 програмын танилцуулга, серверийн вйлдлийн систем суурилуулах, тохируулах, шvvхийн хvний нооцтэй холбоотой болон авилгатай тэмцэх газрын хоронго орлогын мэдvvлэг боглох ажиллагааны талаар мэдээлэл технологийн мэргэжилтнvvдэд танилцуулжээ.

Мон 2 дугаар сарын 18-ны одроос 22-ны одрийн хооронд Нийслэлийн шvvхтэй хамтран “Шvvхийн захиргааны мэргэшсэн албан хаагчдад зориулсан сургалт”-г зохион байгуулж, Нийслэл, дvvргийн шvvхээс нийт 27 хvнийг эхний ээлжинд хамруулсан байна.

Сургалтыг тослийн шугамаар ХБНГУ-д багшаар бэлтгэгдсэн шvvгчийн туслах нар Нийслэл, дvvргийн шvvхийн шvvгч нартай хамтран явуулжээ.

Эрvvгийн хэргийн мониторингийн ажлын хэсэг шинээр батлагдах хуулийн тослийн ажлын хэсэгт орж ажиллаж байгаа богоод тослийн толовлогоогоо шинэчлэн гаргаж, прокурорын байгууллагын программтай эрvvгийн байцаан шийтгэх ажиллагааны программыг уялдуулах асуудлыг судлаж байна.

Эвлэрvvлэн зуучлах тогтолцоог сайжруулах тослийн хувьд 2 сарын 20-оос 23-ны хооронд сургалт явуулсан байх богоод сургалтад оролцогчдыг орон тооны эвлэрvvлэн зуучлагч бэлтгэгдээгvй байсан аймаг, дvvргээс tvлхvv сонгосон талаар Эвлэрvvлэн зуучлах тогтолцоог сайжруулах тослийн зохицуулагч Ока Хидео танилцуулав. Сургалтад 69 хvн хамрагдаж гэрчилгээ авснаар одоогийн байдлаар улсын хэмжээнд 222 хvн уг сургалтад хамрагдаж гэрчилгээ авчээ.

Шvvхийн шийдвэр гvйцэтгэх албаны удирдлагуудтай уулзаж, шvvхэд хэрэгжvvлж буй мониторингийн программыг Шvvхийн шийдвэр гvйцэтгэлийн байгууллагын хийж буй программтай уялдуулах, цаашид хамтран ажиллах талаар уулзалт хийсэн талаар хуралдаан дээр Мэдээлэл технологийн тасгийн дарга Д.Монхзориг мэдээлэв.

Мониторингийн зовлолийн ээлжит хуралдаан 2013 оны 3 дугаар сарын 29-ний 15 цагт болно.